



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 80

Мандалговь

“Эрдмийн далай Хүүхэд хөгжлийн төв” ОНӨААТҮГ-ын  
төлөөлөн удирдах зөвлөлийг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Эрдмийн далай Хүүхэд хөгжлийн төв” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

ТУЗ-ийн дарга:  
Гишүүд:

Эрдэнэдалай сумын Засаг дарга  
Эрдэнэдалай сумын ИТХ-ын  
нарийн бичгийн дарга  
Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын  
дарга  
Эрдэнэдалай сумын Санхүү  
албаны дарга  
Эрдэнэдалай сумын  
нийгмийн бодлогын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

2. Орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан дүрмийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ